



ЭМ ЭС ЭЛ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Г.БОЛОРМАА ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**  
**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН**  
**ДҮГНЭЛТ**

Нийслэлийн Засаг захиргааны III байр,  
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: (976) 7799 0101

Цахим шуудан: [ubhd@emg.ub.gov.mn](mailto:ubhd@emg.ub.gov.mn)  
Цахим хуудас: [www.ubhealth.mn](http://www.ubhealth.mn)

2023.05.12 № 10-13-02/021/196

Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт  
хийсэн тухай

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 4.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх тухай" 10-00/07 дугаартай удирдамжийг үндэслэн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч М.Нэргүй би 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр 248 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн МЗХ2022/07-004 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавартай. Батлагдсан загвар зурагтай.

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр, бохир ус гэсэн иж бүрэн ажлын зургийг "Эм Эс Эл" ХХК-д 2023 онд боловсруулсан.ЕТ, БА, ББ зургийн шифр MSL-23-06.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 248 дугаар цэцэрлэгт 2760 м.кв газрыг олгосон Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000002007 дугаартай гэрчилгээтэй.

Зураг төслийн товч агуулга:

Цэцэрлэгийн барилга тэнхлэгээрээ 34.5\*21.5м хэмжээтэй, зоорьтой 2 давхар, төмөр бетон каркасан рамтай, блокон барилга. Зоорийн давхарыг цонхтой байгалийн гэрэлтүүлэг тусахаар төлөвлөсөн.

1150500398

Цэцэрлэгийн барилгын зоорийн давхарт шатны хонгил, хонгил, ажилчдын хувцас солих өрөө, шүршүүр, ариун цэврийн өрөө, цагаан хэрэглэл угаалгын өрөө, сан, арга зүйн төв, бусад өрөө, цахилгаан, холбооны техникийн өрөөнүүд төлөвлөсөн;

1-р давхарт шатны хонгил, хонгил, ажилчдын хувцас солих өрөө, шүршүүр, ариун цэврийн өрөөтэй, хүнсний 2 агуулах, 13.59 м.кв угаалга, бэлтгэлийн өрөө, 53.79 м.кв хоол боловсруулалтын хэсэгтэй гаднаас орох хаалга бүхий гал тогоо, гадагш хаалгатай тусгаарлах өрөөтэй, хөмчийн өрөө, 2 ангитай, анги бүр хүлээн авах өрөө, ор хураах өрөө, ариун цэврийн өрөөтэй, 82 м.кв бүлгийн өрөөтэй, ХБИ, ажилчдын ариун цэврийн өрөөтэй;

2-р давхарт шатны хонгил, хонгил, 3 ангитай, анги бүр хүлээн авах өрөө, ор хураах өрөө, ариун цэврийн өрөөтэй, 82 м.кв бүлгийн өрөөтэй, 105 м.кв урлаг заал, оффис өрөө төлөвлөсөн байна.

Ус хангамж: УСУГ-ын 2023 оны 32/23, Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн В-У2023/86 техникийн нөхцөлтэй, "УБЦТС" ТӨХК-н 2023 оны 15/00448/23 техникийн нөхцөлтэй. ХИХУГ-ын 2023 оны СДС01/2023 техникийн нөхцөлтэй.

Агаар сэлгэлт: Барилгын агаар сэлгэлтийн агаар соруулах механик системийг цагаан хэрэглэл угаалга, хоол үйлдвэрлэлийн өрөө, урлаг зааланд, хүнсний 2 агуулахын хэсэгт, бусад өрөө тасалгаанд ердийн систем төлөвлөсөн.

Инженер геологийн судалгааны талаар:

"Жоншт-Уул" ХХК-ийн 2022 онд хийсэн инженер геологийн судалгаагаар барилга барихаар сонгосон талбай дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй, хөрсний ус 2.4-3.0м-т илэрсэн. Суурийн нүхийг ухсаны дараа буурь хөрсний хяналт хийлгэх шаардлагатай гэсэн байна. /архивын №3130/

Цаашид анхаарах асуудал. Зоорийн давхарын өрөө, тасалгааны зориулалтыг 5.1.10-д нийцүүлэх

ДҮГНЭХ НЬ:

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр 248 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөл нь Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 193 дугаар тушаалаар батлагдсан Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга төлөвлөлт норм, дүрэм-ийн эрүүл ахуйн холбогдох шаардлагад нийцэж байна.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛБЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



ЗӨВШӨӨРСӨН.

ЭМ ЭС ЭЛ ХХК-ИЙН ЗАХИРАЛ -2 Г.БОЛОРМАА